



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/50

Хөхбүрд

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын А/39 дугаар "Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж батлах тухай" тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 08 А/203 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэх сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн малын их эмч Т.Энх-Амгалан, Л.Сэргэлэн, Б.Лхагвасүрэн нарт хариуцуулсугай.

4. Дээрх ажлыг технологит хугацаанд гүйцэтгэн хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн тасаг, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

ДАРГА  БАЯМБАДОРЖ



642501007

Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01 өдрийн 150 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



МАЛ, АМЬТНЫ ШИМЭГЧТЭХ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ 2025 ОНЫ МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АРГА ХЭМЖЭЭ

2025 оны 05 дугаар сарын 01


Хөхбүрд

№	СУМЫН НЭР	УГААЛГА/МЯН,ТОЛ/				ТУУЛГА/МЯН,ТОЛ/						БОЛОВСРУУЛАЛТ/МЯН,ТОЛ/				ГУУРЫН БОЛОВСРУУЛАЛТ 2 УДАА /МЯН,ТОЛ/		НИЙТ МАЛ/МЯН,ТОЛ/	аж ахуйн нэгж
		ҮХЭР	ХОНЬ	ЯМАА	НИЙТ	АДУУ	ҮХЭР	ХОНЬ	ЯМАА	НОХОЙ	НИЙТ	ҮХЭР	ХОНЬ	ЯМАА	НИЙТ	ҮХЭР	НИЙТ		
1	Мандалхайрхан 1 дүгээр баг	1120	17400	14600	33120	260	230	13700	11000	40	24740	190	8710	7300	16200	190	190	74250	Амгалан ариун сүрэг ХХК малын их эмч Т.Энх-Амгалан
2	Уранхайрхан 2 дугаар баг	1200	18800	18300	38300	360	240	11300	11000	40	22940	195	7540	7330	15065	195	195	76500	Хишиг тайжын овоо ХХК малын эмч Б.Лхагвасүрэн
3	Асгамба 3 дугаар баг	1130	11970	7250	20350	168	220	7180	4350	30	11948	220	4790	4347	9357	220	220	41875	Асгамба хоршоо малын эмч Л.Сэргэлэн
4	Мэргэн 4 дүгээр баг	700	7890	7080	15670	160	140	4740	4250	30	9320	110	3160	2840	6110	110	110	31210	
	Нийт	4150	56060	47230	107440	948	830	36920	30600	140	69438	715	24200	21817	46732	715	715	224325	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН
МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСГИЙН ТАРХВАР
ЗҮЙЧ *[Signature]* Ж.ЖАМЪЯНДАГВА



Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар
сарын 01-ны өдрийн 1/30 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх
арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд хяналт
тавих тухай удирдамж

Нэг. Зорилго

Малын шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, тархалт, халдварлалтыг таслан зогсоох малд тарга тэвээрэг бүрэн авхуулах, зооноз өвчнөөс сэргийлэх зорилгоор мал сүргийг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

Хоёр. Хугацаа

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Хэрэгжүүлэх бүрэлдэхүүн

Сумын мал эмнэлгийн тасаг, багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж нартай хамтран хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Сумын мал эмнэлгийн тасаг, МЭҮН

4.1.1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан шимэгчтэх өвчинтэй тэмцэх сэргийлэх зааврыг чанд баримтлах;

4.1.2. Шимэгчдийн эсрэг эм бэлдмэлийг малын эмч үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэх ба малчид, мал бүхий иргэд дур мэдэн хэрэглэсэн бол сумын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч тухайн хот айл, эрчимжсэн мал аж ахуйгаас мал, амьтны тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх эрхийг гурван сараар хязгаарлах, Зөрчлийн тухай хуулийн 13.9-2, 13.9-6.1-д заасан заасан шийтгэлийн арга хэмжээг авч ажиллана.

4.1.3. Сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч Ж.Жамъяндагва шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тэмцэх арга хэмжээг цахим системд төлөвлөх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч нарыг арга зүйгээр хангах, арга хэмжээг гүйцэтгэлийн цахим системд тухай бүрд нь

шивүүлэх, гүйцэтгэлийг оруулахдаа хавсралт хэсэгт хэрэглэсэн бэлдмэлийн зургийг цувралын хамт хавсаргах;

4.1.4. МУ-ын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан, МЭЭСБУЛ-ийн сорилт, баталгаажуулалтын дүнтэй шимэгчтэх өвчний эм бэлдмэлүүдээр угаалга, туулгалт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэх;

4.1.5. Малын шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний ач холбогдол, үр дүнгийн талаар малчдад сурталчилгаа хийх, шимэгчтэх өвчнi хор уршгийг таниулах;

oooOooo

